



ᠴᠢᠩᠭᠢᠰᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠯᠲᠠᠨ ᠤᠷᠭᠢᠢᠨ ᠤᠭᠢᠨ ᠪᠢᠴᠢᠭ

Чингисийн алтан ургийн
Угийн бичиг
Činggis-un altan uruγ-un
Uγ-un bičig

(Бөрт Чоноос 1919 он хүртэл)

УГИЙН БИЧИГ - МОНГОЛЧУУДЫН ҮНДЭСНИЙ БАХАРХЛЫН ИХ ХӨЛГӨН СУДАР

Б.Сумьяабаатар (Монгол)

※ Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэл

※ Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэлийн сүлд сүлдэр (*ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠯᠳᠡᠷ süldeᠷ*)

※ Угийн бичиг ба Монголын Нууц Товчоо

※ Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэлийн нэр

※ Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэлийн уламжилж ирсэн түүх

※ Чингис хааны угийн бичиг (Бөрт Чоноос 1915 он хүртэл)

※ Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэл

" Угийн бичиг " (*ᠤᠭᠢᠨ ᠪᠢᠴᠢᠭ uγ-un bičig*) ба " Гэрийн үеийн бичмэл " (*ᠭᠡᠷᠢᠶᠢᠨ ᠦᠡᠢᠨ ᠪᠢᠴᠢᠮᠡᠯ ger-ün üy-e-yin bičimeᠯ*) ялгаатай. Сүүлийн үед түүнийг зааглахаа больж, юм л бол " Угийн бичиг " гэдэг болсон. Төрийн зарлиг, засгийн шийдвэрт " Угийн бичиг " хөтлөх гэж оржээ. Энэ нь ч учиртай. *Нэгд*, монголчуудын уг удмыг мартуулах бодлого замхарсныг харуулна. *Хоёрт*, угийн бичиг гэрийн үеийн бичмэл гэж ярьж, бичсэн хүнийг ' тайж нарын угийг сэргээх гэж байна ' хэмээн хяхаж хавчиж байсан цаг улирч өнгөрснийг илтгэнэ. *Гуравт*, " Угийн бичиг " гэсэн үг чухам бичмэлдээ тун бага гардаг боловч, ийм нэртомьёо монгол хэлнээ нэгэнт буй. Нөгөөтэйгүүр, " Угийн бичиг " гэдэг нэр хэлэхэд хялбар, бичихэд төвөггүй, дуулахад сонсголонтой уугал монгол үгс. *Дөрөвт*, буриад зон маань, айл бүрийн хөтөлж байдаг, хүн бүр цээжилж байдаг ургийн бичгээ Угийн бичиг (*Угай бэйцэг*) гэдэг нь үнэн. *Тавд*, " Буриадын угийн бичиг " гэдэг ном түүрүүлж гарсан (*Улаанбаатар. 1966 он*) зэргээс " Угийн бичиг " гэдэг нэр тийнхүү нийтэд түгэх болсон байна.

Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэлийн ялгаа нь, хамрах цаг, үеийн тоо, хөглөх журам, хадгалах газар, хүн бүрийн мэдэх цээжлэх хязгаар тус тус өөр өөр байдагт оршино. Тухайлбал, халхад угийн бичгийг айл бүр хөтөлдөггүй, гэртээ хадгалдаггүй. Өрх бүр хөтөлж байдаг ургийн бичгээ ' Гэрийн үеийн бичмэл ' гэдэг.

Угийн бичиг нь арван наймаас дээш өвгөөс юм уу, Бөрт Чоно эсвэл Чингис хаанаа түшлэг (ᠴᠢᠨᠭᠢᠰ ᠬᠠᠨᠠᠭᠠ түшилэг) болгож эхлэсэн байх жишээтэй. Дөч тавин үе дээш өгссөн буюу 1500–гаад жилийн тэртээх, олон салаа салбар бүхүй, хэдэн зуун мянган хүний угийн бичгийг айл бүр хөтөлж хадгална гэдэг дээр цагт ер боломжгүй зүйл. Тийм ч учраас,

- ① Айл бүр хөтөлдгийн нэр нь хүртэл ГЭРтэй холбоотой Гэрийн үеийн бичмэл гэж нэрлэн, гэртээ хадгалдаг ба,
- ② Голдуу 9–18 үеийг багтаасан байдаг ба,
- ③ Шинэ хөвүүн төрөнгүүт л дур мэдэн шууд нэмж бичээд байдаггүй байсан ба,
- ④ Төрлийн дарга (ᠲᠦᠷᠯᠢᠨ ᠳᠠᠷᠭᠠ törlün daruγ-a) ихэвчлэн мэдэж хөтөлж, зохицуулж байдаг байсан ба,
- ⑤ Хөвүүн насанд хүрч, үе залгамжлах буюу, зэргэ (ᠵᠡᠷᠭᠡ jerge) гуйх буюу, цэргийн албанаа мордохын цагт Тамга газрын данс хараатай тулган нягталж, хошууны тамга даруулж мэдүүлдэг байсан ба,
- ⑥ Гэрийн үеийн бичмэлийг захын хүнд үзүүлээд байдаггүйгээр үл барам, үздэг хардаг, хөтөлж бүрдүүлдэг, данс хараатай тулгаж нийцүүлдэг, салхи санваар үзүүлдэг, гадагш гаргадаг өдөр судартай байсан билээ.

Харин, 1920–оод оны үеэс Гэрийн үеийн бичмэлийг маань нүд үзүүрлэж, хүмүүсийн уг удмыг нь албаар умартуулах бодлого явуулж, улмаар хүч хэрэглэх замд орж, эцэст 'зарлигдан' хориглож, бичиг номын мэргэд, тайж ястан, төрлийн дарга, настангуудыг нь баривчлан хөнөөв. Хөөрхийлөлтэй зарим нь түр цагийн бэрхийг даалгүй, тайж гарлын эцгийн нэрээ сольж, хиймэл 'Ард' гаралтай болж ч хөглөв. Хорио цээр хоёр гурван үе буюу 70 орчим жилийн нүүр үзэв. Хэдийгээр бүдгэрч сиймийсэн боловч, монголчуудын өр зүрхнээс Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэлийг нь салгаж чадсангүй. Монгол хүн ухаан зарж, түүнийгээ номын сан, нуух сан (ᠨᠠᠭᠤᠰ ᠰᠠᠩ niyuqu sang, архив)даа халгалуулж, үр ач нартаа цээжлүүлэхийг нь цээжлүүлж, эмэгтэйчүүд нүгэл гэж бодсон ч, суудалдаа далдлах (монголын буриадад бодтой болсон явдал) зэргээр цөвүүн цагийг давж ирлээ.

※ Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэлийн сүлд сүлдэр (ᠰᠦᠯᠳᠡ ᠰᠦᠯᠳᠡᠷ süldeᠷ)

Оюут хүн (Homo sapiens)ий тархи ивэлж, ухаан ундарч билигийн нүдэн нээгдэх сайхан цагтай золголоо, бид. Монголчууд бид буурал эртний эрдэмт түмэн болохыг өв их соёл нь, өрх гэрийн бичмэл түүх нь бэлхэнээ гэрчлэх аж.

Чингисийн алтан ургийн угийн бичиг, гэрийн үеийн бичмэлийн сүнс сүлдэр, аравнай сүншиг(ᠰᠦᠨᠰᠢᠭ ᠰᠦᠨᠰᠢᠭ), утга учир, одоогийн хэлдгээр ач холбогдол нэгэн иж ажээ: †

- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, монголчуудын тусгаар ТОГТНОЛЫН ТУНХАГ БИЧИГ, их хөлгөн судар аж.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, монгол түмний хувь заяаг өвөрлөж, монгол түмэн юүгээ бусдад уусгахгүйгээр бидний үед авч ирсэн ачлалт НОМ юм.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, олон мянган жилийн турш МОНГОЛ УДМАА ТАСЛАХГҮЙ өнөөг хүрч ирсэн монгол түмний үндэсний бахархлын ИХ ХӨЛГӨН СУДАР ажээ.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, өвөг дээдэс маань үе залгамжаа хольцоогүй, төрийнхөө алтан жолоог цэвэр ариун байлгах хэмээсэн эртний уламжлалт СОНГОМОЛ арга байв. Түүнийг чанадлан барьж үе залгамжилж, засаг төрийн эрхийг барьдаг,

хэргэм зэргэ залгадаг байсан тул төрийн тэргүүнд харийн хүн орох хий зай гаргахгүй, тийм боломж олгодоггүй байв.

- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, **МОНГОЛ АЙЛ БҮРИЙН ХЭН Ч** халдашгүй **ШҮТЭЭН ХӨРӨНГӨ**, одооныхоор бол өрх бүрийн үл хөдлөх хөрөнгө нь юм.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, есөн эрдэнээр номоо бүтээгсдийн удам – монгол туургатан бидний **ОЮУНЫ СОЁЛЫН ХОСГУЙ ДУРСГАЛ**.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, орой бүр эр эм, хөгшин залуугүй, баринтагт судраа магнайлан өргөж гэр хороогоо гороолон тойрч, эрдэм арвижихыг бэлгэдэж заншигсдын удам – монгол туургатан биднээс **ХҮН ТӨРӨЛХТНИЙ** далай арвин **СОЁЛЫН САНД ОРУУЛСАН** нэгэн үл хуучрах **ҮЛЭМЖ ХАНДИВ**.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, бодгаль хүн, өрх гэр, овог аймаг, улс гүрний үл тасрах туус залгамжийн ухааныг нэвт шингээсэн цогц дурсгал.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, хальт харахад тайж нарын үе залгамжийн энгийн нэгэн бичиг мэт боловч, **ХҮН ТӨВТ ТҮҮХЭН СУРВАЛЖ** болно.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, өнгөрсөн үе үгүйгээр одоо үгүй, одоо үгүйгээр ирээдүй үгүй хэмээсэн аугаа санаа агуулсан гүн ухааны дэвсгэртэй гар бичмэл, машинд чухаг, ховор дурсгал юм.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, цус ойртож, бие бөлгөн, ухаан мунхаг, удамшлын өвчин согог бүхүй үр ач нартай болохоос **омтгой** (**ᠣᠮᠲᠤᠭᠠᠢ** omtuᠭai, **ᠬᠠᠭᠤᠮᠠᠭᠠᠢ** qayumayai, хуумгай) гүй урьдчилан сэргийлэх чадвартай их хөлгөн **ЭМИЙН СУДАР** мөн. Гэрийн үеийн бичмэлийг хөтлөснөөр махан төрөл, ясан төрөл сайтар ялгарч, долоо ба есөн үе мултарч ясан хагалах (**ᠶᠠᠰᠤᠨ ᠬᠠᠭᠠᠯᠠᠬᠤ** yasun qayalqu) –аас нааш гэр бүл болгодоггүй байсан, тухайлбал, гэрийн үеийн бичмэл нь гэр бүл болох эсэхийг таацуулан зохицуулдаг лавлах байв.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, монгол цус нэн холдож, хэт эрлийзжихээс басхүү сэргийлдэг, тухайлбал, монгол генийг хадгалагч ариун **САХИУС** байлаа. Үүний тул, нэг удмынхан үе үе чуулж, овгийн ахлагч нар Гэрийн үеийн бичмэлээ хэвтүүлэн (**ᠬᠡᠪᠲᠡᠭᠦᠯᠬᠦ** kebtegülkü) тулгаж, зохицуулдаг журамтай байсан.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, урагшаа бичгийн соёлын өмнөх ба бичгийн соёлын эхнээс эх сурвалжтай. Хойшоо бидний үед тулж ирсэн түүхэн замналтай. Үл мэдэгдэх шахам өнө эртнийх тул эх тийшээ баахан шувтан, сүүл тийшээ нэлээн дэлгэр. Дөрвөн зүг, дээд доорд нийлсэн зургаан уулзар (**ᠵᠢᠭᠦᠴᠢᠭᠠᠨ ᠠᠶᠤᠯᠵᠠᠷ** jiguᠴuᠭan ayulᠵar) хийгээд найман зовхисын төв, чиг, босоо, хөндлөн, гулд, дагуу, зөрүү, жишүү, ташуу, голын, хажуугийн, сэжүүрийн ; зуралга зурам (**ᠵᠢᠷᠤᠮ** jirum) ын хавтгай, дуграг, бөмөрцөг (**ᠪᠥᠮᠦᠷᠴᠡᠭ** bömürceg) дэх бүх солбицол (**ᠰᠣᠪᠢᠴᠢᠯ** solbiçal) ын хүний эшийн холбоог илтгэнэ.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, монгол хүн хэзээ, юүг эрхимлэн дээдчилж байсан зэргийг лавлан мэдэх, тэдний гоозүйн таашаал, нэрийн нэвтэрхий толь юм. Монгол хүний нэр бол манай соёлын дотоод гадаад харилцаа, дэлхийн соёл иргэншлийн төвүүдийн харилцан нөлөөлийг харуулна. Чухам хэдий үед ямар соёлын хүрээнүүд ойртон, уулзарлаж (**ᠠᠶᠤᠯᠵᠠᠷᠠᠯᠠᠵᠤ** ayulᠵarlaju), холицолдон, бэлчирлэж (**ᠪᠡᠯᠴᠢᠷᠯᠡᠵᠦ** belcirlejü) байсан, хэдий үед аль нь алиныгаа шахан зайлуулж байсан ул мөрийг тод хадгалан үлдсэн байдаг.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, нэн эртнээс эх сурвалжтайн учир, түүхэн үйл явдал, аман ба бичгийн зохиол, домог судлал, зан заншлын судлалд нэгэн гол хэрэглэгдэхүүний уурхай болно.
- ° Чингисийн алтан ургийн Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэл нь, монгол бичгийн хэл, зөв

бичих дүрэм, нутгийн аялгууны төрх байдал, өвөрмөц онцлогийг агуулсан Их Товчоон аж.

※ Угийн бичиг ба Монголын Нууц Товчоо.

Зарим хүн, Монголын Нууц Товчоог энд тэнд ам дамжиж явсан зүйлийг түүж цуглуулж бичсэн, үйвэр зүйвэр зохиол гэж хэлэх санаа цухалзуулдаг. Чухамдаа тийн үзэх нь учир дутагдалтай.

- Монголын Нууц Товчоог энд тэндээс сураглан түүвэрлэж эвлүүлээгүй, бичгийн эхийг баримтлан бичсэн гэдгийг Нууц Товчооны эхний удам судрын хэсэг баталж өгнө. Чингис хааны узуурыг гаргасан хэсэг л гэхэд 24 үеийн хэдэн арван хүний удам угсааг тэмдэглэжээ. Тэмдэглэх тэмдэглэхдээ, нэг айлын тэргүүлсэн, дунд, бага хөвүүдийн дэс дарааг ч алдуулаагүй. Ахмад буюу тэргүүлсэн хөвүүнийг зүүн гар талд бичээд, түүний салаа салбаруудыг алдалгүй бичсэн байх нь, яавчиг санаан зоргоор үйлдсэн бус, ямар нэгэн бичгийн эхийг харж байгаад нягт нямбай хуулсан шинж төгс харагдана. Хорь гаруй үеийн, тийм олон салаа салбар болсон хүмүүсийг гэргий, зарц, хөлөг морьд, үйл явдал болсон газар орны нэрийн хамтаар цээж мэддэг хүн байсан гэхэд хүүхэд ч итгэхгүй.
- Мөн Нууц Товчооноо олон хүний цолыг тэмдэглэсэн байх ба түүнийг юу ч харалгүй, дураар зохиосон хэмээн үзэх нь, ухаант хүний санаанд орж, амнаас гарч, гараар бичих зүйл хэрхэвч биш. Энд, элбэгийг нь 'баян', мэдэлтнийг нь 'хаан', эзэмшилтэйг нь 'хан', эрэлхэгийг нь 'баатар', бардамыг нь 'догшин', оночитойг нь 'мэргэн', ухаантайг нь 'эцэн', түшлэгтэйг нь 'ноён', үзэсгэлэнтэйг нь 'гоо' гэх зэргээр цоллож бичжээ. Харин 'сохор' гэдгийг 'харалган' хэмээн үзвэл учир дутагдалтай. Тэмдэглэсэн нангиад үсэгт тийм утга огт үгүй. Энэ нь цол бөгөөд саяхан болтол хэрэглэж байсан, гэрийн үеийн бичмэлд олонтаа гардаг 'цүхэр' (ᠴᠦᠬᠡᠷ cühür), 'цүүхүүр' (ᠴᠦᠬᠡᠬᠦᠦᠷ cühühür) гэсэн бичлэгтэй цолын эртний хэлбэр болно.
- Монголын Нууц Товчоо маань 成吉思 中合 中罕 訥忽 札兀 兒 (ch'éngkísì hāhānè hūcháwùér. Činggis qaγan-u huja'ur Чингис хааны хужа'ур) гэж эхлэдэг. 忽札兀 兒 (hūcháwùér. huja'ur, хужа'ур) гэдэг үгийг ихэнх эрдэмтэн монголоор ᠶᠠᠭᠤᠷ (ijaγur, язгуур) гэж буулгадаг. Ерөнхий санаа ба сонгодог монгол бичгийн хэлээр Нууц Товчоог хөрвүүлж байгаа хүний хувьд байж болох зүйл. Гэхдээ Нууц Товчооны үгийн уугал хэлбэр ба уугуул санаа, өнгө өөс (ᠥᠶᠡᠰ öyes)ийг тусгаяа гэвэл "узуур" гэж буулгах нь зүйтэй. Учир нь, монгол хэлнээ ойролцоо утгатай боловч өөр өөрийн өнгө төрхтэй, хэрэглэгдэх байдал нь тус тус ялгаатай ᠶᠠᠭᠤᠷ (ijaγur, язгуур), ᠤᠯᠵᠢᠭᠤᠷ (uļjūγur, узуур), ᠣᠵᠢᠭᠤᠷ (ojuγur, озоор), ᠶᠣᠵᠢᠭᠤᠷ (yojuγur, ёзоор) гэсэн багц үг байдаг. Эдгээрийн дотроос Нууц Товчооны үгийн хэлбэр ба утгад хамгийн ойр, өнө эртнийх нь ᠤᠯᠵᠢᠭᠤᠷ (uļjūγur, узуур) гэдэг үг болно. Иймээс, Монголын Нууц Товчоог хуудам монголоор буулгагсад 忽札兀 兒 (hūcháwùér, huja'ur, хужа'ур) гэдэг энэ үгийг ᠶᠠᠭᠤᠷ (ijaγur, язгуур) гэлгүй, ᠤᠯᠵᠢᠭᠤᠷ (uļjūγur, узуур) гэж буулгах нь зүйтэй ба монгол кирилл үсгээр түүнийг "язгуур" гэлгүй, "узуур" гэж буулгах нь зүйд нийцтэй.

Энэ мэт, Нууц Товчоо бол машинд боловсорсон бичгийн ба аман бичгийн хэлний яруу найруулгатай, өмнөө их ундрагатай, хойноо олон дагуултай оргил бүтээл бөгөөд, Нууц Товчооноос өмнө монголчуудад "Узуурын бичиг" гэсэн бичмэл байсан байна гэж хэлэх бүрэн үндэстэй.

Одоогийнхоор бол тэр нь Угийн бичиг юм.

※ Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэлийн нэр.

Агуулга, уламжлал, зорилго, хийц маяг, хэлбэр төрх, нутаг ус, тухайн ястан үндэстний зан заншил зэргээс хамааран нэр нь өөр өөр байсан. Наад зах нь 65 нэр байгааг мэргэдийн үзэхэд хялбар хэмээн, монгол кирилл үсгийн дэсээр жагсаан толилуулая:

01. Бичиг ᠪᠢᠴᠢᠭ
02. Гэрийн бичмэл хүснэг ᠭᠡᠷᠢᠶᠢᠨ ᠪᠢᠴᠢᠮᠡᠯ ᠬᠦᠰᠡᠨᠭᠡᠲᠦ
03. Гэрийн түүх ᠭᠡᠷᠢᠶᠢᠨ ᠲᠦᠭᠦᠬ
04. Гэрийн түүхний дэвтэр ᠭᠡᠷᠢᠶᠢᠨ ᠲᠦᠭᠦᠬᠢᠨ ᠳᠡᠪᠲᠦᠷ
05. Гэрийн үеийн бичмэл ᠭᠡᠷᠢᠶᠢᠨ ᠦᠶᠡᠶᠢᠨ ᠪᠢᠴᠢᠮᠡᠯ
06. Гэрийн үеийн бичмэл дэвтэр ᠭᠡᠷᠢᠶᠢᠨ ᠦᠶᠡᠶᠢᠨ ᠪᠢᠴᠢᠮᠡᠯ ᠳᠡᠪᠲᠦᠷ
07. Гэрийн үеийн бичмэл түүх ᠭᠡᠷᠢᠶᠢᠨ ᠦᠶᠡᠶᠢᠨ ᠪᠢᠴᠢᠮᠡᠯ ᠲᠦᠭᠦᠬ
08. Гэрийн үеийн бичмэл түүх дэвтэр ᠭᠡᠷᠢᠶᠢᠨ ᠦᠶᠡᠶᠢᠨ ᠪᠢᠴᠢᠮᠡᠯ ᠲᠦᠭᠦᠬ ᠳᠡᠪᠲᠦᠷ
09. Гэрийн үеийн бичмэл цадиг ᠭᠡᠷᠢᠶᠢᠨ ᠦᠶᠡᠶᠢᠨ ᠪᠢᠴᠢᠮᠡᠯ ᠴᠠᠳᠢᠭ

10. Гэрийн үеийн бичмэлийн өргөх дэвтэр 11. Гэрийн үеийн зураг 12. Гэрийн үеийн зурвас 13. Гэрийн үеийн түүх 14. Данс 15. Данс дэвтэр 16. Дэвтэр данс 17. Дэвтэр данс 18. Зураг бичмэл 19. Зураг бичмэл 20. Илтгэл түүхийн бичиг 21. Илтгэл шастир 22. Намтар 23. Өргөсөн дэвтэр данс 24. Өргөсөн түүх 25. Өргөсөн хэрэг 26. Өргөсөн цэс 27. Өргөх гэрийн үеийн бичмэл цадиг 28. Өргөх данс 29. Өргөх дэвтэр 30. Өргөх зураг 31. Өргөх түүх 32. Өргөх цэс 33. Тууж 34. Түүх 35. Тэмдэглэл 36. Уг, гэрийн үеийн бичмэл 37. Уг зураг 38. Уг салбарын зураг бичмэл 39. Уг тэмдэглэл 40. Уг түүх 41. Уг эх 42. Уг эх бичиг 43. Уг эх гэрийн зураг 44. Уг эх гэрийн түүх 45. Уг эх гэрийн үеийн бичмэл 46. Уг эх гэрийн үеийн зураг 47. Уг эх данс 48. Уг эх зураг 49. Уг эх зураг бичмэл 50. Уг эх салбарын гэрийн үеийн бичмэл 51. Уг эх салбарын зураг бичмэл 52. Уг эх салбарын зураг бичмэл 53. Уг эх түүх 54. Уг эх цэс 55. Уг эх шастир 56. Уг эхийн бичиг 57. Уг эхийн зураг 58. Угийн бичиг 59. Үеийн бичмэл 60. Үеийн зураг 61. Цадиг 62. Цэдиг 63. Цэс 64. Шастир 65. Эх урсгалын бичиг "Эдгээрээс хамгийн олон хэрэглэгддэг нь Гэрийн үеийн бичмэл, Уг эх гэсэн нэрс болно.

᠎ᠤ Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэлийн уламжилж ирсэн түүх.

Монголчууд угийн бичиг, гэрийн үеийн бичмэлээ номын сан, нуух сан(архив)даа ихэвчлэн хадгалж ирсэн. Хувь хүн бичиж тэмдэглэхийн сац, цээжлэхий нь цээжилж, үр хүүхэддээ цээжлүүлэхийг нь цээжлүүлж, аль байдгаараа нууж хааж өдгөө сайхан цагтай золгов. Тийн нэхэн санахад, угийн бичиг ба гэрийн үеийн бичмэл нь

- ᠎ᠠ Монгол улсын Төв номын санд ;
- ᠎ᠡ Буриадын номын санд ;
- ᠎ᠢ Монгол улсын нуух сан буюу архивт ;
- ᠎ᠣ Буриадын нуух сан, дацан хийдэд ;
- ᠎ᠤ Өвөр монгол, Хятад, Тайван зэрэг орны номын сан, музейд ;
- ᠎ᠥ Хувь хүний цуглуулгад тус тус хадгалагдан үлджээ.

᠎ᠠ Монгол улсын төв номын санд байдаг гэрийн үеийн бичмэлүүдийг миний бие 1962 оноос эхлэн үзэж, цэгцэлж, дугтуйлж, бүртгэж, хуулж авсан юм. Йөншөөбү овогт академич Ринчен багштан, сурвалжлагч гишүүн Хөдөөгийн Пэрэнлэй багштан намайг анх эл судлалд сугадаж оруулсан буянтан. Тэр үед, эрдмийн зэргийг нь хүртээдүй боловч үнэхээр эрдэмтэй, ажилдаа дур сонирхолтой, нэн зүтгэлтэй, нүддээ аньж байгаад сугалсан ч хаана ямар ном байгааг олдог туршлагатай Дагва, Молом, Сүрмаажав, Баянзул нарын нэрт номын санч нар байлаа л. Тэднийг, Онход Жамьян гүн тэргүүтэй манай номын санчдын алтан үеийнхэн гэж нэрлэхэд хилсдэхгүй.

᠎ᠠ᠎ᠠ Миний бие буриадад явж номын сан ба дацангуудад байдаг угай бэшэгийг үзэж чадаагүй. Булган аймгийн Тэшиг сумын аварга Очир гэдэг өвгөн надад - манай хамаатан ламд маш олон [газраас дээш 70 см орчим заагаад] угай бэшэг бий. Би нүдээр үзсэн. Ах маань, үхэхээсээ өмнө монголдоо өгчих юмсан гэж ярьдаг. Хоёулаа өвсний тэргэнд суугаад хил гарч очиж авчрах уу гэж цайлган сэтгэлээр хэлж байж билээ. Хилийг тэгж давж яаж болох билээ. Буцаж ирээд тайлангаа тавьж, хүрээлэнгийн захиргаанаас томилолт гуйсан боловч зөвшөөрөөгүй. Тэгээд үзэж чадалгүй өнгөрсөн. Одоо лав буриадын хаа нэгэн газар байгаа байх л даа. Бас, буриадын угай бэшэг, Хорийн ба Агын дүм ба управа нарын хэргийн архивт байдаг байжээ. Чухам хэддүгээр зүйлд байдгийг хүртэл тодорхой зааж тэмдэглэсэн нэгэн гар бичмэлээс эш татая:

“Санавал, угаа мэдээ хэмээхүл: Хорийн ба Агын дүм ба управа нарын хэргийн архиваас 8 дугаар, 9 дүгээр, 10 дугаар ревизээс сүүл бүртгэвэл юунд үл олдох нь. Бэлхэнээ магад олдох агсан бөлгөө. Тэмдэглэгч молхи зөнөг Цэрин Жигжид “ гэжээ. Энэ тэмдэглэл Хуацайн угийн бичигт байдаг. Цэрин Жигжид буюу Жигжидийн Цэрин гэгч хэн бэ гэж лавлан шүүж үзэхэд, мөхөс хүний 1966 онд хэвлүүлсэн Хуацайн угийн бичгийн 19-р тал(П-19-515)д байна. Энэ хүн буриадын нэрт эрдэмтэн Номтын Ринчин(П-31-137)тэй нэг угсааны, Хуацай овгийн хүн байна.

©© Мөн, монгол улсын нуух сан буюу архивт хадгалагдан байгаа гэрийн үеийн бичмэлүүд Өвөр монгол, Хятад, Тайван зэрэг орны номын сан, музейд буй зүйлсийг үзэж чадаагүй

① Гэрийн үеийн бичмэлийн хувийн цуглуулгатай монгол хүмүүс гэвэл:

- **Йөншөөбү Ринчен** багшид буриадын Худай овгийн угай бэшэг байсан. Жамсрангийн Цэвээн авгайн цуглуулгад байсан юм гэнэлээ. Дээр нь тийн бичээд, түүнийгээ 1965 оны 11-р сарын 24-нд надад шилжүүлэн өгсөн, одоо надад байгаа.
- **Хөдөөгийн Пэрэнлэй** багш 1958 онд "Нэгэн гэрийн үеийн бичмэлийн тухай" гэсэн бяцхан товхимол хэвлүүлж байсан болохоор гэрийн үеийн бичмэлийн цуглуулгатай байсан нь гарцаагүй.
- **Батын Буяндэлгэрт** (Дорнод аймаг. Дашбалбар. Ага буриад. Худанц Шарайд. эрэгтэй. 1963 онд 54 настай байсан. Уриагаа мэдэхгүй) худам монголоор бичсэн Худанц Шарайдын "Өөдхэй баатарын 7 хөвүүдийн угийн бичлэг" нэртэй угийн бичиг байв. Түүнийг хуулан авч, эхийг эзэнд нь буцаан өгч, "Буриадын угийн бичгээс" (1966 он) гэдэг ганц сэдэвт зохиолынхоо 137-163-р талд хэвлэсэн. Шарайд нь Хоридой мэргэний 5-р хөвүүн, Худанц нь түүний тэргүүлсэн хөвүүн, Худанц хэмээх Хөхүүр болсон. Энд Буяндэлгэрийн 5 хөвүүнийг тэмдэглэсэн байх ба тэдгээрийн дотроос Борхондай гэдэг хөвүүн нь монгол гүн хэвлэлийн нэрт мэргэжилтэн.
- **Чойвон Содном** (Дорнод аймаг. Ага буриад. Худанц Шарайд. эрэгтэй. Эцгийнхээ 43 насан дээр буюу 1927 онд төрсөн. 1964 онд 37 настай байсан. Уриагаа мэдэхгүй.) худам монголоор бичсэн Худанц Шарайдын угийн бичиг бий гэсэн. Нүдээр үзээгүй. Буяндэлгэр гуайд байсан Шарайдын угийн бичигт Содном(V-20-396)ын уг эх байгаа ба түүний Эрдэмбилэг, Батбилэг гэдэг хоёр хөвүүнийг тэмдэглэжээ.
- **Мятавын Юндэнд** (Дорнод аймаг. Баян-Уул. Ага буриад. Баруун Хуацай. эрэгтэй. 1962 онд 56 настай байсан. Уриагаа мэдэхгүй) худам монголоор бичсэн Хуацайн угийн бичиг байсан. Түүнийг хуулан авч, эхийг эзэнд нь буцаан өгч, "Буриадын угийн бичгээс" (1966 он) гэдэг ганц сэдэвт зохиолынхоо 33-121-р талд хэвлүүлсэн. Тэрбээр Түдэв хэмээх хөвүүнтэй
- **Дэлэгийн Дамбажамцад** (Дорнод аймаг. Баян-Уул. Ага буриад. Оргодой Бодонгууд. эрэгтэй. 1962 онд 51 настай байсан. Уриагаа мэдэхгүй) худам монголоор бичсэн Оргодой Бодонгуудын дөрөвдүгээр хөвүүн Зардаханы угийн бичиг байсан. Түүнийг хуулан авч, эхийг эзэнд нь буцаан өгч, "Буриадын угийн бичгээс" (1966 он) гэдэг ганц сэдэвт зохиолынхоо 217-222-р талд хэвлүүлсэн. Тэрбээр Батбаяр хэмээх хөвүүнтэй.
- **Лубсаны Дашбалбарт** (Дорнод аймаг. Баян-Уул. Ага буриад. Оргодой Бодонгууд. эрэгтэй. 1963 онд 37 настай байсан. Уриагаа мэдэхгүй) худам монголоор бичсэн Оргодой Бодонгуудын угийн бичиг байв. Түүнийг хуулан авч, эхийг эзэнд нь буцаан өгч, "Буриадын угийн бичгээс" (1966 он) гэдэг ганц сэдэвт зохиолынхоо 179-216-р талд хэвлүүлсэн. Тэрбээр Дашдорж хэмээх хөвүүнтэй.
- **Сэживийн Махбадарт** (Дорнод аймаг. Дашбалбар. Ага буриад. Доргоши Галзууд. эрэгтэй. 1963 онд 58 настай байсан. Уриагаа мэдэхгүй) шинэ үсгээр бичсэн Доргоши Галзуудын угийн бичиг байсан. Түүнийг хуулан авч, эхийг эзэнд нь буцаан өгч, "Буриадын угийн бичгээс" (1966 он) гэдэг ганц сэдэвт зохиолынхоо 31-32-р талд хэвлэсэн. Тэрбээр Юра хэмээх хөвүүнтэй.
- **Сэживийн Махбадар** (Дорнод аймаг. Дашбалбар. Ага буриад. Доргоши Галзууд. эрэгтэй. 1963 онд 58 настай байсан. Уриагаа мэдэхгүй)ын ээжид шинэ үсгээр бичсэн Моотгон Харганын угийн бичиг байсан. Түүнийг хуулан авч, эхийг эзэнд нь буцаан өгч, "Буриадын угийн бичгээс" (1966 он) гэдэг ганц сэдэвт зохиолынхоо 165-178-р талд хэвлэсэн.
- **Ю. Дорждуламд** (Хэнтэй аймаг. Дадал. эмэгтэй) худам монголоор бичсэн Хуацайн угийн бичиг байсан. Түүнийг хуулан авч, эхийг эзэнд нь буцаан өгч, "Буриадын угийн бичгээс" (1966 он) гэдэг ганц сэдэвт зохиолынхоо 123-128-р талд хэвлэсэн. Эзэн нь эмэгтэй хүн учраас угийн бичигтээ нэр нь байгаагүй.
- **Гомбын Мятавд** (Дорнод аймаг. Дашбалбар. Ага буриад. Лэглүүд Хөвдүүд. эрэгтэй. 1963 онд 34 настай байсан. Уриагаа мэдэхгүй.) шинэ үсгээр бичсэн Лэглүүд Хөвдүүдийн угийн бичиг байсан. Түүнийг хуулан авч, эхийг эзэнд нь буцаан өгч, "Буриадын угийн бичгээс" (1966 он) гэдэг ганц сэдэвт зохиолынхоо 129-136-р талд хэвлэсэн. Тэрбээр Мягмар, Мягмарлодон хэмээх хөвүүдтэй.
- **Сандагийн Галсанцэрэнд** (Дорнод аймаг. Баян-Уул. Ага буриад. Хөвдүүд. эрэгтэй. 1963 онд 31 настай байсан. Уриагаа мэдэхгүй) шинэ үсгээр бичсэн Хөвдүүдийн угийн бичиг байсан. Түүнийг хуулан авч, эхийг эзэнд нь

буцаан өгч, “Буриадын угийн бичгээс”(1966 он) гэдэг ганц сэдэвт зохиолынхоо 134-136-р талд хэвлэсэн.

- Мөн, буриадын гарал, домогсудлалаар сонирхолтой бүтээл туурвисан, эрдэмтэн доктор Тойсон Галсанд өөрийнх нь хөхүүрийн угийн бичиг буй.
- Г.Ринчэнсамбуу докторт буриадын Оргодой Бодонгуудын угай бэшэг байсан. Чойбалсан аймгийн Баян-Уул сумын 3-р багийн ард Дэлэгийн Дамбажамцаас хуулж авсан бөгөөд буриадын угийн бичгийг хэвлүүлэх гэж байна гэж сонсоод надад өгсөн нь одоо байгаа.

- “Хээ Хас” компанийн захирал, “Монгол судлалын шилдэг бүтээл” нэрт цувралыг санаачлан, монгол хүний хольн хараат, өгөөмөр сайхан, нэгэн үзүүрт сэтгэлээр эл ороо бусгаа цагт хэвлэн нийтлэж байгаа Боржгин овогт Хиад яст Балдандугарын Эрдэмбатын цуглуулганд “Засагт хан аймгийн бэйсийн зэргэ засаг улсын цогтой түшээ гүн ДамдинАбиша-гийн хошууны тайж нарын уг эх гэрийн түүх”, “Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны дэд сайд дүүрэгч чин вангийн зэргэ засаг төрийн жүн ван Намхайжанцан миний биеэс дараалан хошууны тайж нарын гэрийн уг эх түүх” гэсэн нэртэй гэрийн үеийн бичмэлүүд [бас өөр бий гэсэн] байсныг миний бие энэ удаа хэвлүүлж байна.

Цохон тэмдэглэвээс зохих нэг зүйл бол, "Буриадын угийн бичгээс"(Улаанбаатар, 1966 он) хэвлэгдэн гарснаас хойш нэг хэсэг чимээ тасарснаа (гэвч судалгааны ажил үргэлжилсээр байв) 1980 оны сүүлээс Угийн бичгийн тухай яриа сэргэсэн явдал юм. "Мандухай сэцэн хатан" кинонд Батмөнх даян хан Угийн бичиг дэлгэн харж байгаагаар гардаг. Кино зохиолдоо байгаагүй энэ хэсгийг миний бие оруулсныг үзэгч түмэн мэдэхгүй байх. Үүнийг найруулагч Балжинням, жүжигчин Сувд, зурагчин Амгалан, эрдэмтэн Наваан, номын санч Энхтөр нар мэдэх учиртай. Юү гэвэл, тэр үед, кино үйлдвэрийн хажууханд үзэсгэлэн гарч, Мандухай сэцэн хатан кино хийж буйг сурталчилж, хүмүүсийн санал авч байсан цаг. Бид хэсэг эрдэмтэн очиж үзэж санал сэтгэгдлээ ярих үед миний бие

– Монголчуудад угийн бичиг гэж байсан, хаан ширээ залгамжлуулахдаа түүнийг заавал зэж, дагадаг байсан. Мандухай сэцэн хатны нэрийг бичсэн Угийн бичиг ч байдаг юм гэхэд, Балжинням

– Юү гэнээ? Тэр чинь тэгээд хаана байдгийг гэж асуухад нь

– Улсын номын санд байдгийг, би нүдээр үзсэн гэхэд,

– Яасан сонин юм бэ, Тэгээд бүр Мандухай сэцэн хатан гэж байх уу гэж асуухад,

– Сэцэн Мандухай гэж дурайтал бичсэн байдгийг гэхэд

– Түүнийгээ Та олж ирж чадах уу? гэхэд

– Чадахыг бодоё гээд гарч, номын санд очиж учрыг гаргаж гуйсанд зөвшөөрч, номын санч Энхтөр бид хоёр, ГАЗ– 69 машинаар авчирсанд Балжинням ихэд олзуурхан үзсэнээ, шууд л шар торгонд ороогоод, Сувдааг дуудан бариулж, шатны уруу бууж ирж байгаагаар зураг авхуулсан нь кинонд гардаг. Миний урам орж, буу халж, Балжиннямд хандан

– Балжиннямаа, өөр нэг зүйл байна гэхэд

– Юү вэ? гэлээ.

– Хаан хүний малгайн урд хаддаг бололтой, Алтан хүний дүрс Булганы Өвгөнт гэдэг газраас, булшнаас гарсан. Миний хажууд байгаа археологич Наваан олсон. Түүнийг Батмөнх даян ханы малгайд хадаж болохгүй юү гэхэд, Балжинням, зураач Амгаланг дуудаж асуухад, Амгалан – дуулга малгайг хийгээд, зураг аваад дууссан. Өвлийн малгайн урд дээр хадаж болох уу гэхэд Балжинням тэр дор нь зөвшөөрөхөд, Амгалан надаас эх гэрэл зургийг авч дууриалган зураад, хэв сийлж үйлдээд, Батмөнх даян ханы өвлийн малгайн магнайд хадсан нь кинонд гардаг.

Балжиннямтай солонгост уулзахдаа энэ тухай хэлэхэд, санаж байна билээ. Кино зохиолд нь байхгүй эдгээр зүйлсийг түүхэн утга, сувд сондор болгон оруулсан нь ерөнхий найруулагч Балжиннямын авхаалж, ухаан, зоригийг илтгэх бөгөөд, түүхийн тоосонд дарагдахаас нь өмнө, түүнийг тэнхрүүлэн бичив.

Үүнээс гадна, уг гарлаа тогтоох хүсэлтэн олширов. Гэрийн үеийн бичмэл ба ураг төрлийн бичгээ нэхэн сэргээж эхлэв. Ингэхэд, ураг төрлийн бичиг нь эмэгтэйчүүдийг хүртэл хамардаг тул, урьд цагийн гэрийн үеийн бичмэлийг бодвол өргөн хүрээтэй. Нутаг усныхан нь цуглаад Овгийн ахлагчаа сонгодог болжээ. Энэ нь урьдынхаар бол Төрлийн ахлагч юм. Одоо цагт Гэрийн үеийн бичмэл, төрлийн бичгээ хөтлөж буй хүмүүсийн заримаас дурдвал:

- Содномсэнгийн Дамбийням (ерөнхий сайд Амарын нарийн бичиг асан). Үе залгамж нь:

... ← Цэрэн ← Содномсэнгэ ← Дамбийням ← Баатарсүх ← Зоригт,

← Бат–Өлзий ← Батзориг,

← Бат–Эрдэнэ ← Мөнх–Эрдэнэ болно.

- Очирын Чимэд. Ховд аймаг. Алтай сумын 1–р багийн нутаг Наран гэдэг газар 1938 оны 6–р сарын

25–нд төрсөн. Захчин. Харчин овогтой. Ураг төрлийн бичгээ хөглөдөг. Үе залгамж нь:
... ← Харчин ← Баатар ← Очир ← Чимэд ← Сайханбилиг ← Өнөбилиг болно.

- Сандагсүрэнгийн Бадамхатан. Түшээт хан аймаг, Дархан чин ван Пунцагцэрэнгийн хошуу. Одоогийн Төв аймгийн Эрдэнэ сумын уугал иргэн. Түүхийн шинжлэх ухааны дэд эрдэмтэн. Нэрт угсаатны зүйч. Үе залгамж нь: ... ← Дондог(?) тэргүүн ← Сүжигт тэргүүн (1900–2. Богдын шавьд орсон) ← Гэлэгжамц тэргүүн (1931) ← Сандагсүрэн тэргүүн ← Бадамхатан(хөвүүдийнхээ нэрсийг надал бичиж өгөөдүй) болно.
- Чорос Даваацэрэнгийн Бирадамба. Сайн ноён хан аймаг, одоогийн Архангайн Хотонтын уугал иргэн. Эдийн засагч. "Зая хутагтын сунтгийг шүүх болов уу" гэсэн нэн сонирхолтой ном бичиж хэвлүүлсэн (УБ. 1999 он). Үе залгамж нь: ... ← Хархул ← Баатар хунтайж... ← Яринпил тайж ← Дамиран тайж ← Дэлгэр тэргүүн зэргэ тайж. Өөлд бэйсийн хошуу туслагч ← Эрдэнэ–Очир тайж ← Жамьянсүрэн тайж. Сангийн яам, Гадаад яаманд туслах түшмэл, Хотонтын хошуу дарга, Эрдэнэ Булган уулын хошуу даргын алба хашиж байжээ.
- Балдандугарын Эрдэнэбат. Сэцэнхан аймгийн уугал иргэн. "Хээ хас" компанийн захирал. "Монгол судлалын шилдэг бүтээл" нэрт цувралыг санаачлагч. Боржгин овогт Хиад яст, номын болон бусад ховор цуглуулга ихтэй хүн. Үе залгамж нь: ... ← Гомбодорж ← Балдандугар ← Эрдэнэбат болно.
- Арьяадагва. Түшээт хан аймаг. Одоогийн Архангай аймгийн ханы хошуу (Хашаат, Хархорин, Бүрд)ны уугал иргэн. Химийн шинжлэх ухаан эрдэмтэн. Үе залгамж нь: ... ← Эрэнхүү тайж ← Мөнх–Очир тайж(эээ охин нь Арьяадагвын эх Дашээвэг) ← Гомбосүрэн тайж (хувьсгалын эхэн үед амьдарч асан).
- Угийн бичгээс бид, монгол хүний нөхөн үржихүйн асар их хэрэглэгдэхүүнийг олж үзэж болно, жишээлбэл: Абадай (ᠠᠪᠠᠳᠠᠢ Abadai, 1-40-848) сайн ханы дүү Түмэнхэн (ᠲᠦᠮᠡᠩᠬᠡᠨ Tümengken, 1-40-854) гэхэд л 19 эрэгтэй хүүхэдтэй байсан:

∴... ᠲᠦᠮᠡᠩᠬᠡᠨ Tümengken(1-40-854).... ᠵᠣᠳᠪᠠ Jodba(1-41-941)

∴... ᠬᠡᠨᠳᠦᠰᠢᠬᠡᠪᠡ Kendüskibe(1-41-942)

∴... ᠴᠡᠷᠢᠨ Čerin(1-41-943)

∴... ᠯᠣᠶᠠᠭ Loyay(1-41-944)

∴... ᠷᠠᠵᠠᠶᠠᠭ Rajayay(1-41-945)

∴... ᠴᠡᠰᠢᠬᠡᠪᠡ Českibe(1-41-946)

∴... ᠵᠠᠮᠪᠠᠵᠢᠷ Jambum(1-41-947)

∴... ᠪᠠᠮᠵᠢᠷ ᠳᠠᠨᠵᠢᠨ Bamjur Danjin(1-41-948)

∴... ᠪᠢᠮᠯᠡᠭᠢᠷᠳᠡᠢ Bimlegirdei(1-41-949)

∴... ᠰᠢᠨᠠᠷᠠᠶᠰᠠᠳ Sinaraysad(1-41-950)

∴... ᠰᠡᠷᠵᠡ Serje(1-41-951)

∴... ᠰᠡᠩᠭᠡᠨᠵᠡᠢ Senggerjei(1-41-952)

∴... ᠪᠠᠶᠠᠷᠵᠠ Bayarja(1-41-953)

∴... ᠭᠦᠮᠦ Gümü(1-41-954)

∴... ᠰᠣᠨᠣᠮ Sonom(1-41-955)

∴... ᠰᠠᠮᠤᠷ Samur(1-41-956)

∴... ᠲᠠᠷᠢᠮᠤᠶᠠᠭ Tarimayay(1-41-957)

∴... ᠬᠡᠨᠳᠦᠰᠢᠵᠠᠪ Kendüsjab(1-41-958)

∴... ᠬᠣᠬᠦᠭᠡᠢ Kökügei(1-41-959) мөнхүү удмын

ᠵᠣᠨᠲᠤ Jontu(1-40-861).... ᠠᠩᠭᠠᠲᠤ Angyatü(1-41-964)

- ∴... ᠳᠠᠶᠠᠴᠠᠢ Dayaqai(1-41-965)
- ∴... ᠲᠤᠤᠴᠠᠢ Tuuqai(1-41-966)
- ∴... ᠳᠣᠷᠵᠢ Dorji(1-41-967)
- ∴... ᠣᠰᠢᠶ᠋ᠠᠨ Osiyan(1-41-968)
- ∴... ᠢᠷᠵᠢᠭᠡᠢ Irjigei(1-41-969)
- ∴... ᠭᠡᠷᠡᠯ Gerel(1-41-970)
- ∴... ᠰᠦᠮᠡᠨᠳᠡᠢ Sümendei(1-41-971)
- ∴... ᠰᠦᠮᠢᠷ Sümür(1-41-972)
- ∴... ᠴᠣᠶᠲᠤ Coytu(1-41-973)
- ∴... ᠭᠦᠮᠪᠦ Gumbü(1-41-974)
- ∴... ᠪᠠᠶᠠᠲᠤᠷ Bayatur(1-41-975)
- ∴... ᠳᠠᠶᠢᠴᠢᠩᠭ Dayičing(1-41-976)
- ∴... ᠣᠮᠪᠣ Ombo(1-41-977)
- ∴... ᠴᠢᠩᠪᠠᠶᠠᠲᠤᠷ Čing Bayatur(1-41-978) 15 эрэгтэй хүүхэдтэй байсан гэх мэт.

※ **Чингис хааны угийн бичиг**

Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэлийн судлагаа нь угтаа Чингисийн алтан ургийн хаад, тэдний удам угсааны судлал юм. Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэлийн тухай ярихад, хаад ноёдын язгуурын хаагуур нь ч тойрч гарахын аргагүй. Нэг үе манайд хаалттай сэдэв байлаа. Хэдийгээр үе залгамжлахаа больсон ч, цус нь зүрхэн толт(ᠲᠣᠯᠲᠤ tolta)оор нь гүйсээр буйг мэддэг, мэддэггүй олон сая хүн дэлхий дэхинд аж төрсөөр байнам. Энэ нь одоогийн Монголоор зогсохгүй Евразийн асар уудам нутгийг хамарсан Их монгол улсын Чингис, Өгөөдэй, Гүюг, Мөнх, монголын Юан гүрний Хубилай зэрэг их хаад, бага хаад, Зөчийн улс, Цагаадайн улс, Алтан ордны улс, Ил хаад, тэдний удмынхны түүхэн Товчоон болох учиртай. Газар нутаг уудам, сэдэв дэлгэр, бүтээл арвин, хэл олон, нас богино тул, хүчин мөхөстөх хийгээд, хаадын багын нэр, өргөсөн нэр, алдаршсан нэр, сүмийн цол, амьдарсан ба ширээнээ заларсан он цаг зөрөх зэрэг будлихад хялбар зүйл их буй.

Одоо, Бөрт Чоноос эхлээд 1919 он хүртэлх, мянга гаруй жилийн түүхийг багтаасан монголчуудын Угийн бичгийг толилуулая. Хэрхэн үзэж угаа олох, яаж залгах ухаан, өвөг дээдсийн тань хэргэм цол, зэрэг тушаал, хуучин шинэ засаг захиргаа, нэрсийн хэлхээ, хэний хөвүүн болох зэргийг нарийвчлан зааж өгөв. Жишээлбэл, бидний сайн мэдэх Авдай сайн хан нь Нонохын хөвүүн, 1–40–848–д байгаа Abadai(1-40-848) болно. 1–нь угийн бичгийн дугаар, 40–нь үеийн дугаар, тухайлбал, Бөрт Чоноос нааш 40 дүгээр үеийн хүн гэсэн үг, 848–нь Авдай гэдэг хүний хувийн дугаар бөгөөд уул угийн бичигт давтагдахгүй.

Үе Нэр

▼ ▼

᠋ᠰ

∴

- 1 ▶ ᠪᠣᠷᠦᠴᠢᠨᠠ Börte-Činu-a(1-1-1) ... ᠭᠣᠮᠠᠨᠠᠯ Gowa Manal(1-1-2)
- 2 ▶ ᠪᠠᠲᠠᠴᠢᠭᠠᠨ Batači qan(1-2-3)
- 3 ▶ ᠳᠠᠮᠠᠴᠠ Damača(1-3-4)
- 4 ▶ ᠶᠣᠷᠢᠴᠠᠷᠮᠡᠷᠭᠡᠨ Qoričar Mergen(1-4-5)
- 5 ▶ ᠠᠶᠤᠵᠢᠮᠪᠣᠷᠠᠴᠤᠯ Ayujim Boruqul(1-5-6)

6 ▶ *Salı Qajaqu*(1-6-7)

7 ▶ *Yeke Nidün*(1-7-8)

8 ▶ *Simsoči*(1-8-9)

9 ▶ *Qarču*(1-9-10)

Буриадын Угийн бичиг

↑

↑ :

10 ▶ *Borjigidai Mergen*(1-10-11)... *Monggoljin Gowa*(1-10-12) : *Baryudai*

: *Mergen*(1-10-13)

: [*Baryu Bayatur*]

11 ▶ *Toruyuljin Bayan*(1-11-14)... *Boruy čin Gowa*(1-11-15) :

Qorilardai *Bar yujin*

:

.....

[*Qoridai*] *Mergen*(1-11-16)..... *Gowa*(1-11-17)

:

:

:

12 ▶ *Duwa Soqur*(1-12-18) *Dobun Mergen*(1-12-19) *Alan Gowa*(1-12-20)

13 ▶ *Duwa Soqur*(1-12-18)... *Donui*(1-13-21)

... *Doysin*(1-13-22)

... *Emneg*(1-13-23)

... *Erke*(1-13-24)

Dobun Mergen(1-12-19)... *Bügünüdei*(1-13-25)

... *Belgünüdei*(1-13-26)

Alan Gowa(1-12-20) ... *Buqu Qatagi*(1-13-27)

... *Buqutu Salji*(1-13-28)

:

... *Bodunčar Mongquy*(1-13-29) ... *Ablin em-e*(1-13-30)

/ Ablin em-e-yin inji(1-13-31)

/ jarjü yu d adangqan uriyanqajin(1-13-32)

14 ▶ *Bodunčar Mongquy*(1-13-29)... *Barim sigiretü Qabiči Bayatur*(1-14-33)

... *Jegüredei*(1-14-34)

... *Bayaridai*(1-14-35)

... *Jajiradai*(1-14-36)

15 ▶ *Barim sigiretü Qabiči Bayatur*(1-14-33)... *Menen Tüdün*(1-15-37)

Bayaridai(1-14-35)... *Čiduqul Bökü*(1-15-38)

Jajiradai(1-14-36)... *Tügüküdei*(1-15-39)

16 ▶ *Menen Tüdün*(1-15-37)... *Qači Kölüg*(1-16-40)... *Nomulun*(1-16-41)

- ∴.. **Qačín**(1-16-42)
- ∴.. **Qačiyu**(1-16-43)
- ∴.. **Qačula**(1-16-44)
- ∴.. **Qačiyun**(1-16-45)
- ∴.. **Qarandai**(1-16-46)
- ∴.. **Načín Bayatur**(1-16-47)

Tügüküdei(1-15-39)... **Bori Bolčiru**(1-16-48)

17 ▶ **Qači Kölüg**(1-16-40)... **Qayidu**(1-17-49)

- Qačín**(1-16-42)... **Noyagidai**(1-17-50)
- Qačiyu**(1-16-43)... **Baruladai**(1-17-51)
- Qačula**(1-16-44)... **Yeke Barula**(1-17-52)

∴.. **Öcüken Barula**(1-17-53)

- Qačiyun**(1-16-45)... **Adarkidai**(1-17-54)
- Načín Bayatur**(1-16-47)... **Oruyudai**(1-17-55)

∴... **Manggudai**(1-17-56)

∴... **Sijiyudai**(1-17-57)

∴... **Toyladai**(1-17-58)

Bori Bolčiru(1-16-48)... **Qar-a Qadayan**(1-17-59)

18 ▶ **Qayidu**(1-17-49)... **Bai Singqur Doysin**(1-18-60)

∴.. **Čaryai Lingqu**(1-18-61)

∴.. **Jaujín Öртеgei**(1-18-62)

Qar-a Qadayan(1-17-59)... **Jamuq-a**(1-18-63)

19 ▶ **Bai Singqur Doysin**(1-18-60)... **Tumbinai Sečen**(1-19-64)

Čaryai Lingqu(1-18-61)... **Senggün Bilge**(1-19-65)

∴... **Besüdei**(1-19-66)

∴... **Gintü Činu-a**(1-19-67)

∴... **Ölügčün Činu-a**(1-19-68)

Jaujín Öртеgei(1-18-62)... **Orunar**(1-19-69)

∴... **Qongqutan**(1-19-70)

∴... **Arulad**(1-19-71)

∴... **Sönid**(1-19-72)

∴... **Qabturqas**(1-19-73)

∴... **Genükes**(1-19-74)

20 ▶ **Tumbinai Sečen**(1-19-64)... **Qabul Qayan**(1-20-75)

∴... **Sem Sečüle**(1-20-76)

Асанга Сеггүн Senggün Bilge(1-19-65)... Амбайга Qayan(1-20-77)

Бесүдега Besüdei(1-19-66)... Балақачага Balaqači(1-20-78)

21 ▶ Qabul Qayan(1-20-75)... Окін Барқага Okin Barqaq(1-21-79)

∴... Бардан Байатуга Bardan Bayatur(1-21-80)

∴... Qutuıtu Mönğkür(1-21-81)

∴... Qotula Qayan(1-21-82)

∴... Qulan Bayatur(1-21-83)

∴... Qadayan(1-21-84)

∴... Tödügen Odčigin(1-21-85)

Асанга Сем Сеçүле Sem Seçüle(1-20-76)... Билтеçү Байатуга Bülteçü Bayatur(1-21-86)

Амбайга Qayan(1-20-77)... Qadayan(1-21-87)

22 ▶ Окін Барқага Okin Barqaq(1-21-79)... Qutuıtu Jürki(1-22-88)

Бардан Байатуга Bardan Bayatur(1-21-80)... Mönğgetü Kiyan(1-22-89)

∴... Negün Tayiji(1-22-90)

∴... Yesügei Bayatur(1-22-91)... Ögelün Üjin(1-22-92)

∴... / Dayina γ si(1-22-93)

∴... / So čegel(1-22-94)

∴... / Menggilün(1-22-95)

∴... Daritai Odčigin(1-22-96)

Qutuıtu Mönğkür(1-21-81)... Buri Bökü(1-22-97)

Qotula Qayan(1-21-82)... Jöči(1-22-98)

∴... Kirmayu(1-22-99)

∴... Altan(1-22-100)

Qulan Bayatur(1-21-83)... Yeke Čeren(1-22-101)

Qadayan(1-21-87)... Tarqudai Kiriltuy(1-22-102)

∴... Qoril(1-22-103)

∴... Ayuçi Bayatur(1-22-104)

23 ▶ Qutuıtu Jürki(1-22-88)... Seče Beki(1-23-105)

∴... Tayiču(1-23-106)

Negün Tayiji(1-22-90)... Qučar Beki(1-23-107)

Yesügei Bayatur(1-22-91)... Temüjin(1-23-108)... Bönte Üjin(1-23-109)

∴... / Qulan Saran(1-23-110)

∴... / Yisüküü(1-23-111)

∴... / Yisügen(1-23-112)

∴... Qasar(1-23-113)

∴... Qaçiyun(1-23-114)

ᠲᠡᠮᠦᠭᠡ ᠣᠳᠴᠢᠭᠢᠨ Temüge Odčigin(1-23-115)

ᠪᠡᠭᠲᠡᠷ Begter(1-23-116)

ᠪᠡᠯᠦᠭᠦᠳᠡᠢ Belgüdei(1-23-117)

ᠳᠠᠷᠢᠲᠠᠢ ᠣᠳᠴᠢᠭᠢᠨ Daritai Odčigin(1-22-96)... ᠳᠠᠭᠢᠨᠡᠭᠡᠨ Daqneyev(1-23-118)

ᠶᠡᠬᠡ ᠴᠡᠷᠢᠨ Yeke Čeren(1-22-101)... ᠨᠠᠷᠢᠨ ᠭᠡᠭᠡᠨ Narin Gegen(1-23-119)

24 ▶ ᠲᠡᠮᠦᠵᠢᠨ Temüjin(1-23-108).... ᠵᠥᠳᠦᠴᠢ Jöči(1-24-120)

ᠴᠠᠶᠠᠳᠠᠢ Čayadai(1-24-121)

ᠥᠭᠡᠳᠡᠢ Ögedei(1-24-122)

ᠲᠤᠯᠤᠢ Tolui(1-24-123)

ᠥᠷᠦᠴᠢ Örüči(1-24-124)

ᠬᠥᠯᠭᠡᠨ Kölgen(1-24-125)

ᠵᠥᠷᠴᠢᠨ Jörčin(1-24-126)

ᠵᠥᠷᠴᠢᠳᠡᠢ Jörčidei(1-24-127)

ᠶᠠᠰᠠᠷ Qasar(1-23-113).... ᠶᠡᠬᠦ Yekü(1-24-128)

ᠶᠢᠰᠦᠩᠬᠡ Yisüngke(1-24-129)

ᠲᠤᠶᠤ Toyu(1-24-130)

ᠪᠠᠭᠲᠠᠨᠳᠠᠷ Baqtandar(1-24-131)

ᠶᠠᠯᠠᠷᠴᠢ Qalarču(1-24-132)

ᠰᠠᠷᠮᠠᠨ ᠪᠥᠭᠡ Šarman Böge(1-24-133)

ᠶᠠᠴᠢᠷᠢᠭᠤᠨ Qačiyun(1-23-114)... ᠠᠯᠴᠢᠭᠢᠳᠠᠢ Alčigidai(1-24-134)

ᠲᠡᠮᠦᠭᠡ ᠣᠳᠴᠢᠭᠢᠨ Temüge Odčigin(1-23-115).... ᠣᠳᠤᠨ Odun(1-24-135)

ᠵᠢᠪᠬᠡᠨ Jibken(1-24-136)

ᠰᠢᠳᠡᠬᠢ Sideki(1-24-137)

ᠶᠠᠰᠢᠳᠠᠢ Qasidai(1-24-138)

ᠴᠡᠴᠢᠯᠡ Čččile(1-24-139)

ᠲᠤᠯᠢᠴᠢ Toliču(1-24-140)

ᠣᠷᠤᠳᠠᠢ Orudai(1-24-141)

ᠪᠠᠶᠢᠭᠤ Bayiqu(1-24-142)

ᠪᠡᠯᠦᠭᠦᠳᠡᠢ Belgüdei(1-23-117).... ᠶᠢᠰᠦ ᠪᠤᠭᠤᠠ Yisü Buq-a(1-24-143)

ᠬᠦᠮᠦᠨ ᠪᠤᠭᠤᠠ Kümün Buq-a(1-24-144)

ᠶᠠᠨᠳᠤᠬᠤ Qanduqu(1-24-145)

ᠮᠡᠨᠳᠦ Mendü(1-24-146)

ᠳᠠᠭᠢᠨᠡᠭᠡᠨ Daqneyev(1-23-118).... ᠰᠥᠬᠤᠶᠠ Šoq-a(1-24-147)

ᠬᠥᠬᠡᠴᠦ Kökečü(1-24-148)

25 ▶ ᠵᠥᠳᠦᠴᠢ Jöči(1-24-120).... ᠤᠷᠲᠤ ᠢᠴᠢᠨ Urtu İčin(1-25-149)

(24-р үеийн

ᠪᠠᠲᠤ Batu(1-25-150)

120-р хүн	ᠲᠣᠶ᠋ᠲᠡᠮᠦᠷ Toyatemür(1-25-151)	
буюу Зөчөөс	ᠪᠡᠷᠻᠡ Berke(1-25-152)	
залган үзнэ үү)	ᠰᠡᠨᠢᠪᠠᠩ Senibang(1-25-153)	
	ᠳᠡᠶᠡᠯ Deyel(1-25-154)	
	ᠲᠠᠩᠭᠦᠳ Tangyud(1-25-155)	
	ᠪᠡᠷᠻᠡᠴᠡᠷ Berkečer(1-25-156)	
	ᠴᠢᠯᠠᠭᠤᠨ čilayun(1-25-157)	
	ᠰᠡᠩᠭᠦᠷ Senggür(1-25-158)	
	ᠬᠢᠲᠠᠢ Kitai(1-25-159)	
	ᠮᠣᠭᠠᠮᠡᠳ Moqamed(1-25-160)	
	ᠣᠳᠦ Ödü(1-25-161)	
	ᠰᠢᠬᠤᠬᠦᠮᠦᠨ Siq Kümün(1-25-162)	
	ᠴᠠᠶᠠᠳᠠᠢ Čayadai(1-24-121)...	ᠮᠣᠶᠠᠳᠤᠷᠠᠨ Mojaduryan(1-25-163)
		ᠶᠢᠰᠦᠨᠮᠥᠩᠭᠡ Yisünmängke(1-25-164)
		ᠪᠡᠳᠦᠷ Bedür(1-25-165)
		ᠰᠠᠪᠠ Saba(1-25-166)
ᠣᠭᠡᠳᠡᠢ Ögedei(1-24-122)...	ᠬᠦᠭᠦᠭᠦ Güyüg(1-25-167)	
	ᠬᠠᠰᠢ Qasi(1-25-168)	
	ᠬᠦᠳᠡᠨ Güden(1-25-169)	
	ᠬᠦᠴᠦ Kücü(1-25-170)	
	ᠬᠠᠷᠠᠴᠠᠷ Qaračar(1-25-171)	
	ᠬᠠᠲᠠᠨ Qatan(1-25-172)	
	ᠮᠢᠷᠢ Miri(1-25-173)	
ᠲᠣᠯᠤᠢ Tolui(1-24-123)...	ᠮᠥᠩᠭᠡ Mängke(1-25-174)	
	ᠬᠤᠲᠤᠭᠤᠲᠤ Qutuγtu(1-25-175)	
	ᠬᠤᠪᠢᠯᠠᠢ Qubilai(1-25-176)	
	ᠬᠤᠯᠠᠭᠤ Qulayū(1-25-177)	
	ᠠᠷᠢᠶᠡᠪᠥᠬᠡ Ariγ Böke(1-25-178)	
	ᠪᠥᠵᠦᠭᠦ Böjüg(1-25-179)	
	ᠮᠥᠬᠡ Möke(1-25-180)	
	ᠰᠦᠶᠢᠲᠦᠭᠡ Süyitüge(1-25-181)	
	ᠰᠦᠪᠡᠳᠡᠢ Sübedei(1-25-182)	
ᠬᠥᠯᠭᠡᠨ Kölgen(1-24-125)...	ᠬᠤᠴᠠ Quča(1-25-183)	
ᠶᠡᠬᠦ Yekü(1-24-128)...	ᠠᠶᠢᠨᠪᠠᠶᠠᠨ Ayinbuyan(1-25-184)	
ᠶᠢᠰᠦᠩᠭᠡ Yisüngke(1-24-129)...	ᠰᠢᠳᠤᠷ Sidur(1-25-185)	
ᠪᠠᠭᠲᠠᠨᠳᠠᠷ Baqtandar(1-24-131)...	ᠴᠡᠷᠭᠡᠳᠡᠢ Čergedei(1-25-186)	

Qalarču(1-24-132).... Temür(1-25-187)

... Šari(1-25-188)

... Muqatu(1-25-189)

... Qutuy(1-25-190)

... Šir-a Soyta(1-25-191)

... Lenteyi(1-25-192)

... Qoruy-a(1-25-193)

Šarman Böge(1-24-133).... Engke Sümer(1-25-194)

Alçigidai(1-24-134).... Qatan(1-25-195)

... Čaqula(1-25-196)

... Qulayur(1-25-197)

... Dölün(1-25-198)

Odun(1-24-135).... Ajuru(1-25-199)

... Ayayači(1-25-200)

Jibken(1-24-136).... Tačir(1-25-201)

... Temüder(1-25-202)

Toliču(1-24-140).... Ayayači(1-25-203)

Orudai(1-24-141).... Qaburtu(1-25-204)

... Dasi(1-25-205)

... Kitüge(1-25-206)

Yisü Buq-a(1-24-143).... Güwan-tü(1-25-207)

Kümün Buq-a(1-24-144).... Mergedei(1-25-208)

... Ünggiredei(1-25-209)

Qanduqu(1-24-145).... Quliqi(1-25-210)

Mendü(1-24-146).... Qula(1-25-211)

Kökečü(1-24-148).... Irgen(1-25-212)

26 ▶ Urtu İčün(1-25-149).... Sartaytai(1-26-213)

Batu(1-25-150).... Sartay(1-26-214)

... Toduqan(1-26-215)

... Yadiqan(1-26-216)

... Ulači(1-26-217)

Toyatemür(1-25-151).... Ölügtemür(1-26-218)

Senibang(1-25-153).... Laqadur(1-26-219)

Deyel(1-25-154).... Tatar(1-26-220)

Moyaduyan(1-25-163).... Büri(1-26-221)

... Qar-a Ülekü(1-26-222) ... Ürün-e(1-26-223)

ᠲᠠᠰᠤᠨ ᠲᠤᠤᠠ Tasun Tuwa(1-26-224)

ᠪᠣᠵᠢ Böki(1-26-225)

ᠪᠡᠳᠦᠷ Bedür(1-25-165)... ᠠᠷᠤᠭᠤ Aruyu(1-26-226)

ᠰᠠᠪᠠ Saba(1-25-166)... ᠨᠡᠬᠦᠪᠡᠢ Nekübei(1-26-227)

ᠨᠡᠬᠦᠳᠡᠷ Neküder(1-26-228)

ᠭᠦᠶᠦᠭ Güyüg(1-25-167)... ᠷᠠᠴᠠ Quča(1-26-229)

ᠨᠠᠭᠤ Nuyu(1-26-230)

ᠭᠣᠭᠤ Goqu(1-26-231)

ᠷᠠᠰᠢ Qasi(1-25-168)... ᠷᠠᠶᠢᠳᠤ Qayidu(1-26-232)

ᠭᠦᠳᠡᠨ Güden(1-25-169)... ᠮᠡᠷᠭᠡᠳᠡᠢ Mergedei(1-26-233)

ᠮᠡᠭᠭᠢᠲᠦ Menggitü(1-26-234)

ᠵᠡᠪᠲᠡᠮᠦᠷ Jebtemür(1-26-235)

ᠳᠡᠪᠡᠯ Debel(1-26-236)

ᠬᠥᠯᠷᠦ Kölrü(1-26-237)

ᠬᠦᠴᠦ Kücü(1-25-170)... ᠰᠢᠯᠡᠮᠦᠨ Silemün(1-26-238)

ᠷᠠᠷᠠᠴᠠᠷ Qaračar(1-25-171)... ᠲᠣᠳᠤ Todu(1-26-239)

ᠷᠠᠲᠠᠨ Qatan(1-25-172)... ᠲᠦᠷᠢᠴᠢ Töriči(1-26-240)

ᠡᠪᠦᠭᠡᠨ Ebügen(1-26-241)

ᠢᠳᠡᠷ Ider(1-26-242)

ᠶᠢᠰᠦᠲᠦ Yisütü(1-26-243)

ᠷᠣᠨᠢ Qoni(1-26-244)

ᠬᠢᠪᠴᠠᠭ Kibčay(1-26-245)

ᠮᠢᠷᠢ Miri(1-25-173)... ᠲᠣᠶᠤ Toyu(1-26-246)

ᠮᠣᠩᠭᠡ Mönḡke(1-25-174)... ᠪᠠᠯᠲᠤ Baltu(1-26-247)

ᠠᠰᠤᠳᠠᠢ Asudai(1-26-248)

ᠥᠷᠭᠡᠳᠠᠰᠢ Örgendasi(1-26-249)

ᠰᠢᠷᠬᠢ Sirki(1-26-250)

ᠷᠠᠪᠢᠯᠠᠢ Qubilai(1-25-176)... ᠳᠣᠷᠵᠢ Dorji(1-26-251)

ᠴᠢᠩᠭᠢᠮ Čingḡim(1-26-252)

ᠮᠠᠩᠭᠠᠯᠠ Mangyala(1-26-253)

ᠨᠣᠮᠤᠬᠠᠨ Nomuqan(1-26-254)

ᠬᠥᠬᠡᠴᠢ Kökeči(1-26-255)

ᠠᠶᠠᠴᠢ Ayači(1-26-256)

ᠣᠷᠦᠴᠢ Oručı(1-26-257)

ᠬᠥᠬᠡᠴᠦ Kökečü(1-26-258)

ᠲᠣᠶᠣᠨ Toyon(1-26-259)

- :... **ᠠᠲᠤᠯᠠᠲᠡᠮᠦᠷ** Qotalatemür(1-26-260)
- ᠠᠷᠢᠶᠤ** Qulayu(1-25-177).... **ᠠᠪᠠᠭᠠ** Abay-a(1-26-261)
 - :... **ᠲᠠᠷᠠᠶᠠᠢ** Tarayai(1-26-262)
 - :... **ᠲᠡᠦᠳᠡᠷ ᠠᠬᠡᠮᠡᠳ** Teüder Ahmed(1-26-263)
 - :... **ᠮᠣᠩᠭᠡᠲᠡᠮᠦᠷ** Möngketemür(1-26-264)
 - :... **ᠪᠣᠬᠢᠨ** Bökin(1-26-265)
 - :... **ᠶᠣᠩᠭᠢᠷᠠᠳᠠᠢ** Qonggiradai(1-26-266)
 - :... **ᠡᠷᠢᠨᠴᠢᠨ ᠳᠣᠷᠵᠢ** Erinčin Dorji(1-26-267)
 - :... **ᠴᠣᠮᠶᠠᠷ** Čomqar(1-26-268)
 - :... **ᠢᠰᠢᠮᠦᠳ** Isimüd(1-26-269)
 - :... **ᠪᠣᠷᠤ** Boru(1-26-270)
 - :... **ᠥᠯᠡᠵᠦ** Ölejü(1-26-271)
- ᠠᠷᠢᠶᠤ ᠪᠣᠬᠡ** Ariy Böke(1-25-178).... **ᠮᠢᠩᠯᠢᠲᠡᠮᠦᠷ** Minglitemür(1-26-272)
 - :... **ᠶᠣᠮᠶᠠᠷ** Yomqur(1-26-273)
 - :... **ᠨᠢᠯᠻᠠᠪᠤᠴᠤᠭᠠ** Nilqabuq-a(1-26-274)
 - :... **ᠯᠠᠶᠠᠮᠤᠰᠢᠶᠠᠨ** Layamsiqan(1-26-275)
- ᠪᠥᠵᠦᠭ** Böjüg(1-25-179).... **ᠰᠡᠪᠢᠯᠵᠢᠷ** Sebiljir(1-26-276)
- ᠮᠣᠬᠡ** Möke(1-25-180).... **ᠴᠡᠩᠳᠦᠩ** Čengdüng(1-26-277)
 - :... () (1-26-278)
- ᠰᠦᠶᠢᠲᠦᠭᠡ** Süyitüge(1-25-181).... **ᠰᠦᠪᠡᠳᠡᠢ** Sübedei(1-26-279)
 - :... **ᠶᠠᠯᠤᠰᠤᠨ** Qalusun(1-26-280)
- ᠰᠦᠪᠡᠳᠡᠢ** Sübedei(1-25-182).... () (1-26-281)
- ᠶᠤᠴᠠ** Quča(1-25-183).... **ᠶᠣᠷᠣᠳᠠᠢ** Qorudai(1-26-282)
- ᠰᠢᠳᠤᠷ** Sidur(1-25-185).... **ᠪᠠᠪᠤᠰᠠ** Babuša(1-26-283)
 - :... **ᠪᠢᠯᠭᠦᠦ** Bilgüü(1-26-284)
 - :... **ᠶᠣᠩᠭᠠᠷ** Qonggur(1-26-285)
- ᠴᠡᠷᠭᠡᠳᠡᠢ** Čergedei(1-25-186).... **ᠬᠢᠪᠴᠠᠶ** Kibčay(1-26-286)
 - :... **ᠰᠣᠳᠦ** Södü(1-26-287)
 - :... **ᠬᠣᠬᠡ** Köke(1-26-288)
 - :... **ᠲᠣᠳᠠᠨᠲᠣᠶᠲᠤ** Todantoytu(1-26-289)
 - :... **ᠳᠠᠶᠢᠷᠬᠢᠷ** Dayirkir(1-26-290)
- ᠮᠤᠶᠠᠲᠤ** Muqatu(1-25-189).... **ᠪᠣᠭᠡᠷᠳᠡᠢ** Bögerdei(1-26-291)
 - :... **ᠬᠦᠷᠡᠨᠰᠠᠶᠠ** Kürensay-a(1-26-292)
- ᠶᠣᠲᠤᠭ** Qutuy(1-25-190).... **ᠠᠷᠰᠤᠯᠠᠨ** Arslan(1-26-293)
- ᠰᠢᠷᠠ ᠰᠣᠶᠲᠠ** Šir-a Soyta(1-25-191).... **ᠶᠤᠴᠠ** Quča(1-26-294)
 - :... **ᠵᠠᠮᠴᠢ** Jamči(1-26-295)
- ᠯᠡᠨᠲᠡᠶᠢ** Lenteyi(1-25-192).... **ᠥᠯᠡᠵᠡᠲᠡᠮᠦᠷ** Öljeitemür(1-26-296)

ᠠᠩᠭᠳᠠᠰᠢᠷᠢ Engke Sümer(1-25-194)... ᠠᠩᠭᠳᠠᠰᠢᠷᠢ Angdasiri(1-26-297)

ᠶᠠᠲᠠᠨ Qatan(1-25-195)... ᠶᠠᠲᠠᠨ Qoraču(1-26-298)

ᠴᠠᠯᠠᠯᠠ Čaqula(1-25-196)... ᠶᠡᠷᠢᠻᠢ Yeriki(1-26-299)

ᠶᠤᠯᠠᠶᠤᠷ Qulayur(1-25-197)... ᠮᠣᠨᠠᠰᠤ Monansa(1-26-300)

ᠳᠥᠯᠦᠨ Dölün(1-25-198)... ᠪᠦᠪᠡᠢ Būbei(1-26-301)

ᠲᠠᠴᠢᠷ Tačir(1-25-201)... ᠨᠠᠶᠢᠮᠠᠳᠠᠢ Nayimadai(1-26-302)

ᠶ... ᠪᠦᠪᠡᠢ Ebügen(1-26-303)

ᠶ... ᠣᠯᠠᠷᠭᠢᠳᠠᠢ Olargidai(1-26-304)

ᠶ... ᠣᠰᠤᠴᠠᠢ Osuqai(1-26-305)

ᠶ... ᠴᠠᠯᠠᠴᠠᠢ Čalaqai(1-26-306)

ᠶ... ᠪᠣᠷᠤᠳᠠᠢ Borudai(1-26-307)

ᠲᠡᠮᠦᠳᠦᠷ Temüder(1-25-202)... ᠪᠡᠻᠢᠴᠦ Bekičü(1-26-308)

ᠶ... ᠰᠢᠷᠠᠮᠤ Siramu(1-26-309)

ᠶ... ᠪᠦᠷᠭᠢ Būrgi(1-26-310)

ᠠᠶᠠᠶᠠᠴᠢ Ayayači(1-25-203)... ᠪᠠᠯᠲᠠᠲᠡᠮᠦᠷ Baltatemür(1-26-311)

ᠶᠠᠪᠦᠷᠲᠤ Qaburtu(1-25-204)... () (1-26-312)

ᠳᠠᠰᠢ Dasi(1-25-205)... ᠲᠣᠳᠤ Todu(1-26-313)

ᠬᠢᠲᠦᠭᠡ Kitüge(1-25-206)... ᠲᠦᠲᠡᠮᠦᠷ Tötөmür(1-26-314)

ᠬᠦᠪᠠᠨᠲᠦ Güwan-tü(1-25-207)... ᠲᠡᠮᠦᠷ Temür(1-26-315)

